



**СҮХБААТАР ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Дөнверийн гудамж 13, 11 дүгээр хороолол,
7 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар хот, 14190, Утас: (976) 7007 0109
Цахим шуудан: info@sbd.gov.mn
Цахим хуудас: www.sbd.ub.gov.mn

2024.09.16 № 6-1951
тэнгэйд _____ -ны № _____ -г

**СҮХБААТАР ДҮҮРГИЙН ХУДАЛДАН АВАХ
АЖИЛЛАГААНЫ АЛБАНД**

Дүүргийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй төсөл арга хэмжээнүүдийг гэрээний тусгай нөхцөлд ажил гүйцэтгэх хугацаанаас хамааран боломжит хугацааг тавьж өгдөг.

Лифт засварын ажил нь 30 хонгийн дотор гүйцэтгэхэд боломжит хугацаа гэж үзсэн.

Иймд Үнэлгээний хороо хэлэлцээд ажил гүйцэтгэх хугацааг өөрчилж тендерийн баримт бичигт зааж өгөхөд захиалагчийн зүгээс татгалзах зүйлгүй.



Сүхбаатар дүүргийн Засаг даргын тамгын газар
Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтэс
Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Батбаатар Бат-Эрдэнэ
2024.09.16 13:40



СҮХБААТАР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2024 ОНЫ А/364 ДҮГЭЭР ЗАХИРАМЖААР
БЛЙГУУЛАГДСАН ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр

Дугаар 05

СБД/ХААА

Дүүргийн Засаг даргын 2024 оны А/364 дүгээр захирамжаар байгуулагдсан Үнэлгээний хорооны 4-р дүгээр хурал 2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 16 цаг 00 минутад тус албаны даргын албан өрөөнд эхлэв. Хуралд оролцсон бүрэлдэхүүн:

Үнэлгээний хорооны дарга: Г.Амгалан-Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга
Гишүүн: Г.Нямдорж-Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн Хяналт шинжилгээ, иргэний оролцоо хариуцсан мэргэжилтэн
П.Жавзандулам-Санхүү төрийн сангийн хэлтсийн Сургалт тайлан мэдээ хариуцсан мэргэжилтэн
Ю.Болорцэцэг-Дүүргийн ИТХ-аас томилогдсон иргэн
Нарийн бичгийн дарга: З.Аззаяа - Худалдан авах ажиллагааны албаны Инженерийн тооцоолол, зураг төсвийн хяналт хариуцсан мэргэжилтэн

Г.Амгалан: Үнэлгээний хорооны гишүүдийн ирц 100% байгаа тул хурлаа эхэлж байна гээд Засаг даргын 2024 оны А/364 дүгээр захирамжаар байгуулагдсан Үнэлгээний хороо, Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газраас тендер хянан үзсэн тухай албан бичиг ирүүлснийг хэрхэх тухай хэлэлцэнэ.

ХЭЛЭЛЦЭХ НЬ:

1. Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газраас ирсэн "тендерийн баримт бичиг хянасан тухай" албан бичигтэй танилцаж хэрхэн шийдэх тухай хэлэлцэх
2. Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газраас ирсэн албан бичигт заасан зөрчлийг хэрхэн шийдсэн тухай албан бичиг төлөвлөж хариу мэдэгдэх, тендер зарлах товыг дахин шинэчлэн тогтоох.

Гишүүд: Хэлэлцэх асуудалтай санал нэг байгаагаа илэрхийлэв.

СОНССОН НЬ:

З.Аззаяа: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Тус үнэлгээний хороо нь анхны хурлаараа дүүргийн Засаг даргын 2024 оны А/364 дүгээр захирамжаар үүрэг болгосон дүүргийн төсвийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэхээр батлагдсан ажлуудын ТББ-т тавигдах шалгуур үзүүлэлтийг хэлэлцэж тендер сонгон шалгаруулах ажиллагааг явуулсан. Гэвч 2024.08.28-ны өдөр Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газарт "Оакс экспресс Монголиа" ХХК-аас гомдол гаргаж СБДХААА/20240101150 дугаартай 8-р хороо, Орон сууцны лифт засварын ажлын тендерийг гомдлын дагуу түтгэлзүүлсэн. Тэгвэл 2024.09.09-ний өдөр Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газраас явуулсан албан бичиг манай албанд 2024.09.12-ны өдөр ирсэн байна. Уг албан бичгийг бүрэн эхээр нь уншиж танилцуулсан нь:

"Танай албанаас зарласан "8-р хороо, Орон сууцны лифт засвар" СБДХААА/20240101150 дугаартай тендерийн бичигт баримтад Оакс экспресс Монголиа ХХК-



гаас гомдол ирүүлснийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 58 дугаар зүйлд заасны дагуу хянан үзлээ.

Тендерийн баримт бичгийн ТББ-ийн ТШЗ 19.2-т "... Ажил гүйцэтгэх үнэлэгдсэн үе шатны хуваарийг болон ажил гүйцэтгэх нарийвчилсан график гарган тендерт оролцогчийн эрх бүхий албан тушаалтны тамга тэмдэг, гарын үсгээр баталгаажсан байна" гэж, Гэрээний тусгай нөхцөлийн 4.1-д "Гэрээ байгуулснаас хойш 30 хоногийн дотор ажлыг гүйцэтгэнэ" гэж захиалагч заасан нь Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 -д заасан "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтлана" гэж заасныг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байна.

Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.5.2 дахь заалтад заасны дагуу тендерийн баримт бичгийн тендерийн баримт бичигт холбогдох өөрчлөлт оруулж хэрхэн шийдвэрлэсэн талаар хариу мэдэгдсэний үндсэн дээр тендер шалгаруулалтыг үргэлжлүүлэн явуулахыг даалгаж байна."

Г.Амгалан: Манай үнэлгээний хорооны боловсруулсан ТББ-н дээр Гэрээний тусгай нөхцөлийн 4.1-д "Гэрээ байгуулснаас хойш 30 хоногийн дотор ажлыг гүйцэтгэнэ" заасан нь өрсөлдөх тэгш боломжтой байх зарчмыг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй гэсэн юм байна. Энэ 30 хоногийн хугацааг тус үнэлгээний хороо биш захиалагчаас ирсэн захиалгын дагуу тусгаж өгдөг.

З.Аззаяа: Тийм. Худалдан авалтын захиалгын хуудсыг нягтлан үзлээ. 2024 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 6/1508 дугаартай Дүүргийн Засаг даргын Тамгын газраас дүүргийн Худалдан авах ажиллагааны албаар гүйцэтгүүлэх худалдан авалтын захиалгад "Гэрээний хугацаа – гэрээ байгуулснаас хойш 30 хоногийн дотор ажлыг хийж гүйцэтгэнэ" гэж захиалагч заасан байна. Тиймээс дүүргийн Засаг даргын Тамгын газрын Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтэст албан бичиг төлөвлөж, ШӨХТГ-аас ирсэн албан бичгийн хуулбарыг хавсралтаар явуулж, хэрхэн шийдэх талаар тодруулга авсан нь дээр гэж үзэж байна.

Гишүүд санал нэг байгаа илэрхийлэв.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ :

1. Дүүргийн Засаг даргын 2024 оны А/364 дүгээр захирамжаар байгуулагдсан дүүргийн төсвийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжих СБДХААА/20240101150 дугаартай "8-р хороо, Орон сууцны лифт засвар"-ын ажилд гаргасан гомдлыг Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтсээс тодруулгын хариу ирсэн өдөр хурлын тов зарлаж дахин хэлэлцүүлж, ажиллахыг Үнэлгээний хорооны нарийн бичгийн даргад даалгаж байна.

2. Дараагийн хурлыг тус тендер нээгдэх хугацаанд хуралдахаар товлон.

Үнэлгээний хорооны дарга

Гишүүд

Г.Амгалан Тийм / Үгүй

П.Жавзандулам Тийм / Үгүй

Г.Нямдорж Тийм / Үгүй

Ю.Болорцэцэг Тийм / Үгүй

Тэмдэглэл хөтөлсөн:

Нарийн бичиг:

З.Аззаяа Тийм / Үгүй



СУХБААТАР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2024 ОНЫ А/364 ДҮГЭЭР ЗАХИРАМЖААР
БАЙГУУЛАГДСАН ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 09 дүгээр сарын 16-ны өдөр

Дугаар 06

СБД/ХААА

Дүүргийн Засаг даргын 2024 оны А/364 дүгээр захирамжаар байгуулагдсан Үнэлгээний хорооны 06 дугаар хурал 2024 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 14 цаг 00 минутад тус албаны даргын албан өрөөнд эхлэв. Хуралд оролцсон бүрэлдэхүүн:

Үнэлгээний хорооны дарга: Г.Амгалан-Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга
Гишүүн: Г.Нямдорж-Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн Хяналт шинжилгээ, иргэний оролцоо хариуцсан мэргэжилтэн
П.Жавзандулам-Санхүү төрийн сангийн хэлтсийн Сургалт тайлан мэдээ хариуцсан мэргэжилтэн
Ю.Болорцэцэг -Дүүргийн ИТХ-аас томилогдсон иргэн
Нарийн бичгийн дарга: З.Аззаяа - Худалдан авах ажиллагааны албаны Инженерийн тооцоолол, зураг төсвийн хяналт хариуцсан мэргэжилтэн

Г.Амгалан: Үнэлгээний хорооны гишүүдийн ирц 100% байгаа тул хурлаа эхэлж байна гээд Засаг даргын 2024 оны А/364 дүгээр захирамжаар байгуулагдсан Үнэлгээний хороо тус дүүргийн Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтсээс ирсэн албан бичигтэй танилцаж Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газарт явуулах албан бичгийн талаар хэлэлцэнэ.

ХЭЛЭЛЦЭХ НЬ:

1. Дүүргийн Засаг даргын Тамгын газар, Төлөвлөлт, гүйцэтгэлийн Удирдлагын хэлтсээс ирсэн албан бичигтэй танилцах.

2. Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газраас ирсэн албан бичигт заасан зөрчлийг хэрхэн шийдсэн тухай албан бичиг төлөвлөж хариу мэдэгдэх, тендер зарлах товыг дахин шинэчлэн тогтоох.

Гишүүд: Хэлэлцэх асуудалтай санал нэг байгаагаа илэрхийлэв.

СОНССОН НЬ:

З.Аззаяа: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Уг албан бичигтэй танилцаад зөрчил гэж үзсэн заалт нь Захиалагчаас өгсөн Худалдан авах ажиллагааны албаар гүйцэтгүүлэх худалдан авалтын захиалгын ажил гүйцэтгэх хугацаа дээр тавигдсан зүйл учир тус хэлтэст албан бичиг явуулсан. Өнөөдөр албан бичгийн хариу ирсэн байна. Бүрэн эхээр нь уншиж танилцуулья.

"Дүүргийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй төсөл арга хэмжээнүүдийг гэрээний тусгай нөхцөлд ажил гүйцэтгэх хугацаанаас хамааран боломжит хугацааг тавьж өгдөг. Лифт завсарын ажил нь 30 хоногийн дотор гүйцэтгэхэд боломжит хугацаа гэж үзсэн. Үнэлгээний хороо хэлэлцээд ажил гүйцэтгэх хугацааг өөрчилж тендерийн баримт бичигт зааж өгөхөд захиалагчийн зүгээс татгалзах зүйлгүй." гэсэн тодруулгын хариу ирүүлсэн.



